

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.БАЯРСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ НИЙСЛЭЛИЙН  
ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ

1. Ерөнхий зүйл	Баянзүрх худалдааны төвийн баруун талд явган хүний зам, тохижилт / Баянзүрх дүүрэг 40 дүгээр хороо/
2. Барилгын зам талбай /замын зурвас/-н үзүүлэлт	Төлөвлөж буй явган замын ажлын байршил болон хөрөнгө оруулалтын хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/1486 дугаар захирамжийн хавсралтаас үзэж болно.
3. Ажлын цар хүрээ	Явган замын төрөл хэмжээг мөрдөгдөж буй стандартын дагуу гүйцэтгэнэ. Дээрх стандартын шаардлагын дагуу ажлын зураг төслийг боловсруулж холбогдох байгууллагуудтай зөвшилцөн батлуулах. Геодезийн хэмжилтийг тухайн орчноор нь хэмжилтийг хийлгэж боловсруулагдсан байр зүйн дэвсгэр зураг дээр ажлын зургийг боловсруулна.
4. Ажлын хил хязгаар	БЗД 40-р хорооны нутаг дэвсгэр дэх хороолол дундах, явган хүний замыг шинээр барих
5. Барилгын ажлын зохион байгуулалт	<ol style="list-style-type: none"><li>1. Гүйцэтгэгч гэрээ байгуулсны дараа явган хүний замын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн дагуу ажил эхлэх зөвшөөрөл авна.</li><li>2. Явган хүний замын ажлыг зохион байгуулахдаа явган зорчигч болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг, тэмдэглэгээ г.м/-г бүрэн хангаж ажиллана.</li><li>3. Гүйцэтгэгч байгууллага Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын даргын 2016 оны А/42 тоот тушаалаар батлагдсан <u>“Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага”-ыг засвар шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэх хугацаанд чанд мөрдөн ажиллана.</u> Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан, холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ. Зааврын дагуу фото зургаар баримтжуулаагүй, 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайланд тусгагдаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Зурган баримтжуулалтад зориулалтын метр, рейк, гадас, самбар зэргийг ашиглана. Нөгөө талаас холбогдох БНБД-үүд, техник технологийн</li></ol>

	<p>стандартуудад заасан шаардлагуудыг хангаж ажиллахыг анхаарна уу.</p> <p>4. Тухайн ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр бусад төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч, хүн хүч, машин, механизмын хуваарилалтын графикийг батлуулж ажиллана. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материал хэрэглэх.</p> <p>5. Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд харагдахуйц газар байршуулна. Явган замын ажлыг батлагдсан төлөвлөгөө, аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графикийг хамтатган батлуулна.</p>
6. Бусад	<p>Явган хүний замын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.</p> <p>Ажлын үе шат бүрд нэг цэгээс фото зураг авч, далдлагдсан ажил бүр дээр акт бичиж, инженерээр баталгаажуулна.</p> <p>Явган замын ажлын хэмжээг м2-аар хэмжинэ. Тухайн ажлыг эхлэн бариулсан инженер техникийн ажилтан тус ажлыг бүрэн дуусгаж, баримт бичгийг бүрдүүлэн ажил хүлээлцэх комисс ажиллуулж, ашиглалтад хүлээлгэж өгнө.</p>

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай инженер техникийн ажилтан**

№	Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага /жил/
1	Авто замын инженер	2	3 болон түүнээс дээш
2	Геодезийн инженер	1	3 болон түүнээс дээш
3	Хөдөлмөр хамгааллын инженер	1	3 болон түүнээс дээш

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай машин механизмууд**

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Х/н	Тоо	Хүчин чадал	Тайлбар
1	Усны машин	Ш	1	1-3 тн	Өөрийн
2	Өөрөө ачигч	Ш	1	0.8 м3	Өөрийн болон түрээс
3	Бага оврын ачааны машин	Ш	1	3-5 тн	Өөрийн

4	Индүү /гөлгөр булт/	Ш	1	0.5-4 тн	Өөрийн болон түрээс
6	Дугуйт эксковатор	Ш	1	0.8 м3	Өөрийн болон түрээс

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай  
тоног төхөөрөмжүүд**

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	х/н	Тоо	Хүчин чадал	Тайлбар
1	Нүүдлийн цахилгаан үүсгүүр	Ш	1	30 кВт-аас багагүй	Өөрийн
2	Зөөврийн гагнуурын аппарат	Ш	1	500А	Өөрийн
3	Гар нягтруулагч	Ш	3		Өөрийн
4	Шөнийн цагт ажиллахад ашиглах талбайн гэрэлтүүлэг	Ш	1		Өөрийн болон түрээс
5	Гэрэл ойлгогчтой зөөврийн түмбэ, замын хаалт, зөөврийн тэмдэг, тууз	Хангалттай хэмжээгээр			
6	Бага оврын гар хөрс нягтруулагч төхөөрөмж	Ш	2	90кг, 120кг	Өөрийн
7	Автомат нивелир, теодолит /сүүлийн үеийн/	Ш	1		Өөрийн
8	Талбай дээрх ажлыг фото зургаар баталгаажуулахад шаардагдах багаж хэрэгсэл /Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага 2017-д тусгагдсан/	Ком			Өөрийн

**Хянасан:**

НЗХГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

 /В.Мягмар/

**Боловсруулсан:**

НЗХГ-ын Авто замын хяналтын мэргэжилтэн

 /П.Бержан/

НЗХГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

 /И.Номингэрэл/

2024 оны <sup>01</sup> сарын <sup>25</sup> -ны өдөр